



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А/149

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.6, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан "Барилгын ажлын захиалагчийн дүрэм", Засгийн Газрын 2018 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм", Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар зүйлийн 2.9.5, 3 дугаар зүйлийн 3.1.12 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Албаны хот тохижилтын зардлаас санхүүжигдэн 2019 онд хийгдэх инженерийн хангамжийн болон тохижилт, ногоон байгууламжийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, гүйцэтгэлийг баталгаажуулан, үйл ажиллагаандаа барилга захиалагчийн дүрмийг удирдлага болгон ажиллахыг Инженерийн байгууламжийн хэлтэс /Т.Хэрлэн/, Тохижилт, хог хаягдал удирдлагын хэлтэс /Г.Ууганбаяр/-т тус тус даалгасугай.

2. Тохижилт, ногоон байгууламжийн ажлыг ашиглалтад хүлээн авах үүрэг бүхий Комиссыг хавсралт ёсоор байгуулсугай.


3. Инженерийн хангамжийн болон тохижилт, ногоон байгууламжийн ажлыг ашиглалтад хүлээн авах ажлын удирдамж батлуулж, үйл ажиллагааг холбогдох дүрэм, журмын дагуу зохион байгуулж ажиллахыг ажил хүлээж авах комисс /Ц.Рэгзэдмаа/-т үүрэг болгосугай.

4. Инженерийн хангамжийн болон тохижилт, ногоон байгууламжийн ажлын дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгүүлэн, эзэмшил, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Инженерийн байгууламжийн хэлтэс /Т.Хэрлэн/, Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Г.Ууганбаяр/-т тус тус даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  ТАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019... оны 03 дугаар сарын 01...-ны өдрийн
А/49... дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



ИНЖЕНЕРИЙН ХАНГАМЖИЙН БОЛОН ТОХИЖИЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖИЙН АЖЛЫГ
ДҮГНЭЛТЭЭР ХҮЛЭЭЖ АВАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын ахлагч:	хэсгийн Ц.Рэгзэдмаа	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аудит, дотоод хяналтын хэлтсийн дарга
Гишүүд:	Р.Даваасүрэн	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
	О.Оджаргал	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
	Д.Сүхбат	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
	Д.Лувсанчимэд	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аудит, дотоод хяналтын хэлтсийн мэргэжилтэн
	П.Чойжилжав	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аудит, дотоод хяналтын хэлтсийн мэргэжилтэн
	М.Мэндсайхан	Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний Газрын Барилга, байгууламжийн хяналтын хэлтсийн хяналтын архитектор
	Б.Жаргалдүүрэн	Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын Засвар ашиглалтын хяналтын хэлтсийн Авто замын хяналтын мэргэжилтэн
	Б.Отгонхүү	Баянзүрх дүүргийн Тохижилт нийтийн аж ахуйн хэлтсийн дарга
	Н.Мөнгөн-Эрдэнэ	Сонгинохайрхан дүүргийн Тохижилт нийтийн аж ахуйн хэлтсийн дарга
	Т.Эдмон	Сүхбаатар дүүргийн Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга
	А.Гэрэлт-Од	Чингэлтэй дүүргийн Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга
	Ц.Бат-Эрдэнэ	Хан-Уул дүүргийн Тохижилт нийтийн аж ахуйн хэлтсийн дарга Баянгол дүүргийн Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга
	П.Нарантуяа	Налайх дүүргийн Тохижилт, нийтийн аж

		Д.Хүрэлбаатар	ахуйн хэлтсийн дарга Багахангай дүүргийн Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга
		Д.Дэмчигжав	Багануур дүүргийн Хотын ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга
Нарийн дарга:	бичгийн	Т.Туул	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аудит, дотоод хяналтын хэлтсийн мэргэжилтэн